



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/46

Хужирт сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 01 дүгээр зөвлөмжийн дагуу Ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай хөтөлбөрийн хоол, хүнсний материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг 111489860 (нэг зуун арван нэгэн сая дөрвөн зуун наян есөн мянга найм зуун жаран) төгрөгөөр “Буман сувд” ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Дээрх шалгарсан компанитай гэрээ байгуулж, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж ажиллахыг Ерөнхий боловсролын сургуулийн захирал (А.Гантулга)-д даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилтийг олгохыг Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч (Ч.Оюунцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

250100091